



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/187

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймагт зохион байгуулагдах идэрчүүдийн волейболын бүсийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 1.045.000 төгрөг, Ховд аймагт зохион байгуулагдах идэрчүүдийн волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд 15.000.000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Уг арга хэмжээнд шаардагдах 16 045 000 төгрөг /Арван зургаан сая дөчин таван мянган/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.17-д заасан "Спортын аварга" хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Улсын аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж өндөр хэмжээнд зохион байгуулахыг Биеийн тамир спортын газрын дарга /Г.Цэдэнбал/-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Zax A/187 Ch
02 00821